

**V ДАЛАЙ ЛАМ
АГВААНЛУВСАНЖАМЦ
БА ГАЛДАН БОШГОТЫН
ХАРИЛЦААНЫ ЗАРИМ
АСУУДАЛ**

Д. ЦЭДЭВ

XVII зууны хагаст Манжийн хаанаас «Хязгаар нутаг» гэгчийн талаар явуулж байсан бодлого нь Төвд, Монголын нийгмийн анги давхаргын эсэргүүцэлтэй тулгарч байв. Төвдийн V Далай лам Агваанлуvsанжамц Ойрадын Галдан (1644--1697) бошгот нарын хувийн дотно нууц харилцаа нь Манжийн эзэнт төрийн түрэмгий бодлогыг эсэргүүцэн тэмцэхэд чиглэгджээ.

Энэхүү асуудлыг тодруулан гаргахын тулд Манжийн төрийн «хязгаар нутаг» гэгчийн талаар явуулж байсан бодлогын зарим асуудлыг тодруулах шаардлагатай. Өгүүлэн буй Агваанлуvsанжамц 1642 онд Төвдийн төр, шашныг нэгтгэн захирах болсноор төрийн үйл хэрэгт шашны гүйцэтгэх ролийг бэхжүүлжээ. Шашин нь тухайн нийгмийн ангийн үзэл суртал болж байсан учраас нийгмийн олон анги давхаргын өргөн хүрээнд үйлчилж, төрийн үйлсийг нөхөн тэтгэх нэгдмэл зорилгод төр шашин хоёр харилцан шүтэлцээтэй байв.

XVII зууны хагасын Төвдийн гадаад бодлогын талаар Л. С. Совецкий өгүүлэхдээ «... Далай ламын засгийн газар төвдийн улс төрийн бодлогыг голлон тодорхойлж байсан ...»¹ гэжээ.

V Далай лам болон түүний шадар нар төвдийн биеэ даасан байдлыг хадгалан үлдээх, үүний хамт Төвдийг өөртөө татан ашиглахыг хүсэмжилж байсан Манжийн Энх-Амгалан хааны бодлогыг өнгөндөө хүлээн зөвшөөрсөн дүр үзүүлж байжээ. Нөгөө талаар Манжийн эсрэг ил тэмцэж байсан Галданг нууцаар дэмжиж, дотнын хэлхээ тогтоож байсан явдал нь V Далай ламын манжийг эсэргүүцсэн уян хатан, хүлээцтэй бодлогын илрэл байв.

V Далай лам Агваанлуvsанжамцыг Төвдийг үндэслэгч хэмээн зарим ном зохиолд дурдсан байх бөгөөд «үндэслэгч» гэдэг нь Төвд оронд төр, шашинг хослон барих ёс бүрэн хэрэгжих болсныг хэлж буй юм.

БНХАУ-ын үндэстний түүх судлагч Ван Фүрэн, Сү Вэнчин нарын бичсэн «Төвд үндэстний товч түүх» гэдэг номд Агваанлуvsанжамцыг «1652 онд Манжийн хаан албан ёсоор V Далай лам болгосон»² гэжээ. Агваанлуvsанжамц 1642 онд Төвдийн «Дүгний» буюу төр шашинг хослон барих болсоныг дээр нэгэнт өгүүлсэн бөгөөд харин энэ 2 мэдээ 10 жилээр зөрүүтэй байгаагийн шалтгаан нь Манжийн хаан, Төвдийн шашин, төрийн нэгдмэл удирдлагыг салгаж, Төвдийн биеэ даах гэсэн бодлогыг алдагдуулсантай холбоотой бололтой. Нөгөөтэйгүүр V далай ламд дан ганц шашны хэргийг захируулж, түүнийг төрийн хэргээс хөндийрүүлэн зайлуулж Төвдөд хоёрдмол удирдлага бий болгосноор далай ламын эрхийг хязгаарлахын хамт Төвдийн уламжлалт хоёр ёсны хуулийг хэрэг сэхгүй болгосон нь үүнээс илт байна.

1. Цаньян жамцо «Песни, приятные для слуха» 13-р тал. Издание Текста, перевода с Тибетского, исследование и комментарий Л. С. Савицкого, 1983, Москва.

2. Ван фүрэн, Сүнэнчнн «Төвд үндэстний товч түүх» 111-р тал Цэньдо. 1980

Төвдийн V далай лам Ойрадын Галдантай (1644-1697) нууц харилцаа тогтоож улмаар Галдангийн Манжийн эсрэг ил тэмцлийг дэмжиж байжээ. Галдан бошгот, Манжийн Энх-Амгалан хаан нарын аль аль нь Төвдийн V далай ламыг биедээ татаж ашиглахыг оролдож байжээ. Галдан бошготын үед Ойрадууд Орос, Манжтай харилцаж байснаар барахгүй Төвдтэй шашин төрийн талаар харилцаатай байв. Галдан V далай ламын дэргэд шавилан сууж байхдаа түүнд нэлээд тал олж улмаар тэдний хооронд ойр дотнын холбоо тогтсон байна. Гэвч энэ үед Төвд нь Манж Чин улсын харьяанд нэгэнт орсон байсан учраас ойрад Монголтой биеэ даан харилцаж чадахгүй, Манжийн хааны зарлиг зөвшөөрлийг аясан дагах болсон юм.

Тиймээс ч удалай лам, Галдан нарын харилцаа нууц байдалд явагдаж байжээ. V Далай лам Галданг нууцаар дэмжих болсоны шалтгаан нь нэг талаас Манжийн хүчний илэрхий давуу байдлыг харгалзсан, нөгөө талаар Энх-Амгалангийн бодлогыг аясан дагах байдал үзүүлж манжийг эсэргүүцэх аятай нөхцөл бүрдэхийг хайж байсантай холбоотой.

Энд нэгэн асуудлыг нэмэн өгүүлэхэд Төвдийн V далай ламын (сайд Диваа) байсан Санжаажамц (1653—1705) V далай лам Агваанлуvsан жамцын үхсэнийг Манжийн хаанд мэдэгдэхгүй 13 жил (зарим намтарт 9 жил) нуусан гэдэг. Санжаажамц V далай ламын нэрийн өмнөөс шашин төрийн бүхий л хэргийг түүний байр сууринаас хөтлөн явуулж байсан байна. Санжаажамцын бодлогын талаар Л. С. Савицкий өгүүлэхдээ: «Санжаажамц Умар ба Дорнын хөршүүдийн (Монгол, Хятад Д. Ц.) хооронд төрийн уян хатан бодлогыг тухайлан сонирхож 20 гаруй жил амжилттай явуулсан нь тодорхой юм»³ гэжээ. V далай ламын Галдантай нууц харилцаатай байсан хийгээд Галданг далдуур дэмжиж байсан бодлогыг Санжаажамц үргэлжлүүлэн «Умар ба Дорнын хөршүүдтэй» уян хатнаар зохих бодлого явуулсан нь төр шашинаа бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ гэлтэй. Ван Фүрэн, Сү Вэнчин нар V далай ламыг үхсэнээс хойших Санжаажамцын явуулж байсан бодлогыг тайлбарлаж бичихдээ, «... далдуур элч илгээн хуйвалдаж, Монголын Зүүнгарын цэргийг Төвдөд ирүүлж Төвд дэхь Монголын хошууд аймгийн ноёрхолыг бүрмөсөн хөөн зайлуулж шарын шашны сүм хийдийн бүлэглэлд орон нутгийн эрхийг дангаар бариулах буюу V далай ламын нэрийг хуурамчаар зээлдэж байсан»⁴ гэжээ.

Ван фүрэн, Сү Вэнчин нарын өгүүлсэн «далдуур элч илгээн хуйвалдаж» гэдэг нь Галдантай нууц харилцаж байсныг хэлсэн бололтой.

Санжаажамц Галдан нарын нууц харилцаа нь «Төвд дэх Монгол ба хошууд аймгийн ноёрхол (Гүүш хаан Д. Ц) шарын шашны орон нутгийн эрхийг дангаар барихын тулд гэснээс үзэхэд харин хүч хамтран Манжийн эсрэг тэмцэх гол зорилго агуулж байсан хэрэг юм.

3. Цаньян джамцо «Песни, приятные для слуха» Издание текста перевод с тибетского исследование и комментарии Л. С. Савицкого М., 1983. 13-р тал.

4. Ван Фүрэн, Сү Вэнчин «Төвд үндэстний товч түүх» Чэньдо, 1980 111-112 тал.